

Аудитын код: САГ-2018/5/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Хосжаргал

Утас: 261628 Цахим хаяг: khojiargalts@audit.gov.mn

Улаанбаатар хот



Агуулга

Аудитын гэрчилгээ.....	0
1 Аудитын тайлан.....	1
1.1 Оршил.....	1
1.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл.....	1
1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	2
1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн....	2
1.5 Дотоод хяналт	3
1.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
1.7 Шилэн дансны мэдээлэл	4
1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	4
1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
1.9.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга.....	4
1.9.2 Санхүүгийн тайланд хийсэн залруулга	4
1.9.3 Өглөг дансны талаар.....	5
1.9.4 Авлага дансны талаар.....	5
1.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал	5
1.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
1.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
1.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
1.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	6
1.16 Аудитын үр өгөөж.....	7
2 Менежментийн захидал	8
2.1 Өглөг.....	9
2.2 Авлага.....	9
3 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	11
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	11
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	12
3.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
3.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
3.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	17



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.23 № 01/801
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гаалийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гаалийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323SAG22.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

071496

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Гаалийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн болон өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Гаалийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 3 дугаар сарын 05-наас 2018 оны 3 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Уянга нар аудитыг гүйцэтгэв.



Гаалийн ерөнхий газрын дарга 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2018 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/1011 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

1.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго:

Гаалийн байгууллага нь үндэсний хөгжлийн зорилтод хувь нэмэр оруулах, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, гадаад худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх эрхэм зорилготой.

Гаалийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэг нь гаалийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих, гаалийн мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл гаргах, гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх, гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх, хуульд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудал болно.

Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

1.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 - 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Гаалийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Гаалийн ерөнхий газрын удирдлагаас тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.


Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 1.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 10 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 29 горим, сорил гүйцэтгэв.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Гаалийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2014 оноос хойш бодлогын баримт бичгийг шинэчлэн бооловсруулаагүй байгаа тул дараах асуудлыг дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маяг аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;



- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг болно.

Гаалийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гаалийн ерөнхий газар санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхдээ харьяа 21 байгууллагын санхүүгийн тайланг төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

1.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гаалийн ерөнхий газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/26 дугаар тушаалаар баталсан “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу 2017 онд 6 зорилтын хүрээнд 18 ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө боловсруулж баталсны дотор харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд 3 хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн байна.

Тус алба удирдамжийн дагуу 2 гаалийн газрын 2015-2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 27 зөвлөмж өгсөн байна. Мөн томоохон аж ахуйн нэгж байгууллагын хойшлогдсон гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөлтөд хяналт хийсэн байна. Гаалийн татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрлийн хүчинтэй эсэх, татваргүй барааны дэлгүүрийн горимд байршиж буй барааны мэдээг сар бүр гаргуулах хүрээнд зөвшөөрлийн хугацаа дууссан дэлгүүрийн 30,797.00 ам.долларын барааг улсын орлого болгосон байна. Харьяа гаалийн газар, хороод татваргүй барааны дэлгүүрт сар бүр тооллого хийж, ирүүлсэн мэдээг нэгтгэдэг байна.


Санхүүгийн үйл ажиллагаанд өдөр тутам удирдлага дотоод хяналтыг хэрэгжүүлдэг байна. Мөнгөн гүйлгээ хийх, бараа материал тавьж олгоход хяналт тавих эрх бүхий албан тушаалтнуудын зөвшөөрлөөр хянагдаж, холбогдох зардлуудыг Сангийн сайдын баталсан тушаал, шийдвэрүүдээр зарцуулсан байна.

1.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Гаалийн ерөнхий газрын 2017 оны урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс 27,601.5 сая төгрөг, өөрийн орлогоос 1,253.4 сая төгрөг нийт 28,854.9 сая төгрөг санхүүжихээр батласан байна.

Улсын төсвөөс 27,594.8 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, батлагдсанаас 6.7 сая төгрөг дутуу санхүүжигдсэн байна.

Өөрийн орлогоос 2,363.7 сая төгрөг бүрдүүлж, төлөвлөгөөний 110.2 сая төгрөг буюу 88.5 хувиар давуулсан байна. Сангийн сайдын “Улсын төсвийн байгууллагын 2017 оны үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах тухай” 2017 оны 372 дугаар тушаалаар 790.6 сая төгрөг зарцуулах эрх олгож зарцуулсан байна.



Тайлант онд батлагдсан төсвөөс 27,992.6 сая төгрөг зарцуулж, 97.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд санхүүжилтийн үлдэгдэл 855.7 сая төгрөгийг төв төрийн сангийн дансанд төвлөрүүлжээ.

1.7 Шилэн дансны мэдээлэл

Гаалийн ерөнхий газар “shilendans.gov.mn” цахим хуудсанд дараах мэдээллийг байршуулсан байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)
4. Санхүүгийн нэгтгэсэн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр)
5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйлгээ (Тухай бүр)
6. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)

1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу тохиолдох магадлалтай дансанд хамаарах уламжлалт болон хяналтын эрсдэлийг агуулж байж болзошгүй гэж урьдчилан тооцоолсон бөгөөд батламж мэдэгдлүүдийн хүрээнд 10 аудитын чиглэлд нийт 29 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэлээ.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Гаалийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрснийг доорх байдлаар шийдвэрлэсэн болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд илэрсэн зөрчил

1.9.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга

Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагч болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 4.2. “Нэгтгэлийг дараахь үе шатаар хийнэ: Үүнд 4.2.1 Мөр мөрөөр нэгтгэх горимыг баримтална. Байгууллага санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч орлого, зардал зэрэг үзүүлэлтүүдийг мөр мөрөөр нь нэмэх байдлаар хяналт тавигч байгууллагын болон түүний хяналтад байгаа байгууллагын санхүүгийн тайлангуудыг нэгтгэнэ...” заалтыг зөрчиж мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд 52.6 сая төгрөгийн орлого, зарлагыг, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг 67.4 сая төгрөгөөр тохируулагдаагүй дүнгээр нэгтгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийлгэв.

Түүврийн байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчил

1.9.2 Санхүүгийн тайланд хийсэн залруулга



Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3 дахь бүлгийн 3.6 "Ажиллагчидтай холбогдсон зардлын бүртгэл"-ын дансны бичилтийн зааврыг зөрчиж Цалингийн өглөгөөс орон сууцны авлагыг суутган тооцохдоо цалингийн зардал болон өөрийн үйл ажиллагааны орлогыг 5.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар" Үр дүнгийн тайланд бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулсан 1.9 сая төгрөгийн хөрөнгийг дотоод томилолтын зардалд, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын 0.3 сая төгрөгийн зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж болон бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд тус тус буруу тусгасан байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

1.9.3 Өглөг дансны талаар

Барьцаа дансны үлдэгдэл оны эхний үлдэгдэл 271.5 сая төгрөгөөс тайлант онд олон жил хуримтлагдсан 2008-2013 онд үүссэн 48.7 сая төгрөгийн өглөгийг барагдуулсан ч тайлант оны эцэст 103.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-т "*төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх;*" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Олон жил хуримтлагдсан барьцаа дансанд байгаа үлдэгдлийг өмнөх онуудын ажлын гэрээ, гүйцэтгэл, хүлээлцсэн акт зэргээс тендерийн хэмнэлт, захиалагчийн хяналтын зардал, алданги эсэх, гүйцэтгэгчид буцаан төлөх өглөг эсэхийг тодруулж улсын төсөвт төвлөрүүлэх, гүйцэтгэгчид олгохоор байгаа үлдэгдлийг эзэн холбогдогчид нь олгох арга хэмжээ авах зөвлөмж өглөө.

1.9.4 Авлага дансны талаар

Төв төрийн санд 2014 онд төвлөрүүлж Сангийн яамнаас авах авлагаар бүртгэсэн 12.0 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг авлага барагдаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Сангийн яамнаас авах авлагыг барагдуулах арга хэмжээ авах

1.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Засгийн газрын 2013 оны 123 дугаар тогтоолоор Замын-Үүд хилийн боомтын ачааны автомашин шалган нэвтрүүлэх цогцолборын хяналтын талбай, хяналтын талбайгаас ачааны автомашин болон чингэлэг шалгах рентген тоног төхөөрөмж бүхий цогцолборын хяналтын талбай хүртэлх 2.3 км хатуу хучилттай автозам, үргэлжлүүлэн төмөр замын шилжүүлэн ачих анги хүртэлх 8.7 км, нийт 11 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг гүйцэтгүүлэхэд шаардагдах 33,000.0 сая төгрөгийг Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэхээр шийдвэрлэж, Гаалийн ерөнхий газар /захиалагч/, Хөгжлийн банк /санхүүжүүлэгч/, БНХАУ-ын компани /гүйцэтгэгч/-тэй гэрээг байгуулан гүйцэтгүүлсэн байна. Дээрх зам талбайг Гаалийн ерөнхий газрын дуусаагүй барилга дансанд 31,105.6 сая бүртгэж 2013 оноос ашиглаж байгаа ч барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2017 онд хүлээн авсан байна. Уг гаалийн хяналтын талбайг ашиглагч байгууллагын, 29.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 9.6 км замыг Зам, тээврийн хөгжлийн яаманд шилжүүлэх шийдвэр гараагүйгээс одоог хүртэл ашиглагч болон замын арчлалтыг хариуцах байгууллагын бүртгэлд шилжүүлээгүй байна.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

1.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитаар Гаалийн ерөнхий газрын төсвийн орлого болон өөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд нарийвчилсан горим гүйцэтгэхээр болов.

1.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Гаалийн ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 120.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад залруулга хийлгүүлэв.

Харьяа байгууллагуудын 21 санхүүгийн тайланд төрийн аудитын газар 15, хараат бус аудитын компани 4 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, түүврээр 2 байгууллагын санхүүгийн тайланг хамрууллаа.

Аудитаар нийт 574.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 349.8 сая төгрөгийн зөрчилд залруулга хийлгэж, 1.2 сая төгрөгийн зөрчилд 3 акт, 32.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 191.5 сая төгрөгийн зөрчилд 24 зөвлөмж хүргүүлэв.

Дүгнэлт өгөхөөр аудитад хамрагдсан 19 байгууллагууд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

1.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Гаалийн ерөнхий газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмж бүрэн хэрэгжиж, авлага, өглөгийн барагдуулах зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. Сангийн яаманд авлагыг барагдуулах тухай албан хүсэлт хүргүүлсэн ч тайлант онд шийдэгдээгүй байна. Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдлээс тайлант онд 48.7 сая төгрөгийг барагдуулсан ч зарим гүйцэтгэгч компанийн хаяг тодорхойгүй, үйл ажиллагаа явуулахгүй байгаа шалтгаанаас холбогдож чадаагүйгээс олон жил хуримтлагдсан барьцаа хөрөнгө бүрэн барагдаагүй байна.

1.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР


Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Гаалийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангаар нийт зардал 35,242.6 сая төгрөг бөгөөд 2.0 хувиар буюу 704.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

1.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Гаалийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гаалийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан



заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 1.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

1.16 Аудитын үр өгөөж

Гаалийн ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 2014 онд Төв төрийн санд төвлөрүүлсэн 12.0 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг Сангийн яамнаас авч авлага барагдуулснаар санхүүгийн үр өгөөж, барьцаа дансны үлдэгдэлд байгаа олон жил хуримтлагдсан өглөгийг барагдуулах арга хэмжээ авснаар санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх санхүүгийн бус үр өгөөж үүснэ гэж тооцлоо.



2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Гаалийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



2.1 Өглөг	Тэргүүлэх ач холбогдол №1
<p><u>ҮАГ-ын ажиглалт</u></p> <p>Барьцаа дансны үлдэгдэл оны эхэнд 271.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байснаас тайлант онд олон жил хуримтлагдсан 2008-2013 онд үүссэн өглөгөөс 48.7 сая төгрөгийг барагдуулсан ч тайлант оны эцэст 103.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-т <i>"төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх;"</i> гэсэн заалттай нийцэхгүй байна.</p> <p><u>Эрсдэлүүд</u> Болзошгүй өр төлбөр үүсэх</p>	<p><u>ҮАГ-ын зөвлөмж</u></p> <p>Олон жил хуримтлагдсан барьцаа дансанд байгаа үлдэгдлийг өмнөх онуудын ажлын гэрээ, гүйцэтгэл, хүлээлцсэн акт зэргээс тендерийн хэмнэлт, захиалагчийн хяналтын зардал, алданги эсэх, гүйцэтгэгчид буцаан төлөх өглөг эсэхийг тодруулж улсын төсөвт төвлөрүүлэхээр байгаа үлдэгдлийг төвлөрүүлэх, гүйцэтгэгчид олгохоор байгаа үлдэгдлийг эзэн холбогдогчид нь олгох арга хэмжээ авах</p> <p>Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.</p> <p><u>Төсвийн захирагчийн хариу</u> Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.</p>

2.2 Авлага	Тэргүүлэх ач холбогдол №1
<p><u>ҮАГ-ын ажиглалт</u></p> <p>Төв төрийн санд 2014 онд төвлөрүүлсэн 12.0 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг Сангийн яамнаас авах авлагаар бүртгэсэн авлага барагдаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д <i>"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"</i> гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.</p> <p><u>Эрсдэлүүд</u> Найдваргүй авлага үүсэх</p>	<p><u>ҮАГ-ын зөвлөмж</u></p> <p>Сангийн яамнаас авах авлагыг барагдуулах арга хэмжээ авах</p> <p>Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.</p> <p><u>Төсвийн захирагчийн хариу</u> Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.</p>



2.3 Дотоод хяналт

ҮАГ-ын ажиглалт

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 574.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 328.8 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 1.1 сая төгрөгийн зөрчилд акт, 32.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 191.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна. Өмнөх онд илэрсэн зөрчилтэй харьцуулахад нийт илэрсэн зөрчил 339.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5. "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ...16.5.2 батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийг зориулалт бус, үрэлгэн зарцуулах

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын зөвлөмж

Дотоод хяналтыг сайжруулах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.



3. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.1. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,223,649.9	3,602,629.0
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	275,409.5	854,485.6
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	-	-
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	558,121.5	92,589.2
УРЬДЧИЛГАА	7а, 7б	2,438.6	133,099.5
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	1,387,680.3	2,522,454.7
НӨӨЦИЙН БАРАА	9а	-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		95,819,692.3	121,444,480.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	95,819,692.3	121,444,480.0
Биет хөрөнгө		95,602,941.6	121,298,301.9
Биет бус хөрөнгө	13	216,750.7	146,178.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		98,043,342.2	125,047,108.9
НИЙТ ӨР ТӨЛБӨР		319,816.3	232,387.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	319,816.3	232,387.9
Өглөг	17а, 17б	319,816.3	232,387.9
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		97,723,525.8	124,814,721.1
Засгийн газрын хувь оролцоо		97,723,525.8	124,814,721.1
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		65,798,906.9	65,798,906.9
Хуримтлагдсан үр дүн		27,826,732.0	54,930,747.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		4,097,886.9	4,085,067.1
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		98,043,342.2	125,047,108.9



3.2. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		25,761,080.1	62,338,003.3
ТАТВАРЫН ОРЛОГО		199,218.4	-
Орлогын албан татвар		199,218.4	-
Хувь хүний орлогын албан татвар		199,218.4	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,880,952.5	33,818,003.4
Нийтлэг татварын бус орлого		1,880,487.1	18,283,934.9
Хөрөнгийн орлого		-	-
Тусламжийн орлого		465.4	15,534,068.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		23,680,909.2	28,519,999.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	31,043,223.4	34,649,709.6
УРСГАЛ ЗАРДАЛ		31,043,223.4	34,649,709.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		29,043,370.3	31,492,317.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		16,631,126.6	18,308,710.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,830,547.9	2,044,965.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,972,104.3	1,843,503.1
Хангамж, бараа материалын зардал		482,907.8	436,571.6
Нормативт зардал		48,490.4	274,830.6
Эд хогшил, урсгал засварын зардал		286,329.7	435,254.6
Томилолт, зочны зардал		43,053.2	138,229.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		921,907.5	1,401,908.3
Бараа үйлчилгээний бусад зардал		6,826,903.1	6,608,344.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,999,853.0	3,157,392.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		(5,282,143.3)	27,688,293.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		3,346,589.8	592,904.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(8,628,733.1)	27,095,388.9



3.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	105,716,870.0	-	105,716,870.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	635,388.9	-	635,388.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	106,352,259.0	-	106,352,259.0
Тайлант үеийн үр дүн	(8,628,733.1)	-	(8,628,733.1)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,723,525.8	-	97,723,525.8
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	97,723,525.8	-	97,723,525.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(4,141.1)	-	(4,141.1)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,719,384.8	-	97,719,384.8
Тайлант үеийн үр дүн	27,095,336.3	-	27,095,336.3
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,814,721.1	-	124,814,721.1



3.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		25,879,448.8	31,806,038.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,082,504.0	3,137,223.5
Нийтлэг татварын бус орлого		2,082,504.0	3,137,223.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		23,796,944.8	28,668,815.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		24,987,030.3	29,760,512.4
УРСГАЛ ЗАРДАЛ		24,987,030.3	29,760,512.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		22,522,468.3	26,201,275.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		16,672,537.3	18,198,908.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,866,183.3	2,024,556.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,960,471.4	1,834,934.9
Хангамж, бараа материалын зардал		344,308.9	379,764.6
Нормативт зардал		135,877.1	473,169.7
Эд хогшил, урсгал засварын зардал		573,998.2	1,238,276.5
Томилолт, зочны зардал		42,253.8	139,048.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		824,046.1	1,468,877.7
Бараа үйлчилгээний бусад зардал		102,792.4	443,739.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,464,561.9	3,559,236.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		892,418.5	2,045,526.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		911,844.8	1,466,450.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		911,844.8	1,466,450.0
Дотоод эх үүсвэрээр		911,844.8	1,466,450.0
Гадаад эх үүсвэрээр		-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(911,844.8)	(1,466,450.0)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		(19,426.3)	579,076.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		294,835.7	275,409.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		275,409.5	854,485.6



3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,854,949.8	27,992,604.1	862,345.7	97.0
УРСГАЛ ЗАРДАЛ	27,454,949.8	26,599,258.2	855,691.6	96.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,090,130.7	25,676,085.0	414,045.7	98.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,383,246.4	18,161,589.3	221,657.1	98.8
Үндсэн цалин	10,520,758.7	10,373,462.2	147,296.5	98.6
Нэмэгдэл	5,158,630.1	5,113,317.6	45,312.5	99.1
Унаа хоолны хөнгөлөлт	752,342.5	745,056.5	7,286.0	99.0
Урамшуулал	1,544,263.4	1,537,630.8	6,632.6	99.6
Гэрээт ажлын хөлс	407,251.7	392,122.4	15,129.3	96.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,051,392.7	2,016,935.5	34,457.2	98.3
Тэтгэврийн даатгал	1,413,361.8	1,316,527.6	96,834.2	93.2
Тэтгэмжийн даатгал	163,374.6	143,295.9	20,078.7	87.7
ҮОМШӨ-ний даатгал	130,699.7	168,694.4	(37,994.7)	129.1
Ажилгүйдлийн даатгал	32,674.8	38,214.2	(5,539.4)	117.0
Эрүүл мэндийн даатгал	311,281.8	350,203.4	(38,921.6)	112.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,853,467.2	1,814,049.2	39,418.0	97.9
Гэрэл, цахилгаан	1,030,814.2	1,011,939.0	18,875.2	98.2
Түлш, халаалт	590,978.9	577,132.6	13,846.3	97.7
Цэвэр, бохир ус	97,747.4	91,703.7	6,043.7	93.8
Байрны түрээс	133,926.7	133,273.8	652.9	99.5
Хангамж, бараа материалын зардал	382,539.7	381,316.1	1,223.6	99.7
Бичиг хэрэг	48,277.2	48,305.4	(28.2)	100.1
Тээвэр, шатахуун	189,308.2	189,086.8	221.4	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,294.4	40,105.1	189.3	99.5
Ном, хэвлэл	47,773.0	47,030.0	743.0	98.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,575.0	19,454.0	121.0	99.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	37,311.9	37,334.8	(22.9)	100.1
Нормативт зардал	465,453.3	464,945.5	507.8	99.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,140.0	4,139.7	0.3	100.0
Хоол, хүнс	29,650.0	29,650.0	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	431,663.3	431,155.8	507.5	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	902,936.1	890,916.0	12,020.1	98.7
Багаж, техник, хэрэгсэл	90,851.2	85,966.2	4,885.0	94.6
Тавилга	-	-	-	-
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,250.7	22,594.5	1,656.2	93.2
Урсгал засвар	787,834.2	782,355.3	5,478.9	99.3

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Томилолт, зочны зардал	183,745.7	139,048.3	44,697.4	75.7
Гадаад албан томилолт	35,074.5	22,526.5	12,548.0	64.2
Дотоод албан томилолт	148,671.2	116,521.8	32,149.4	78.4
Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,523,077.2	1,468,794.0	54,283.2	96.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,029,906.2	980,216.7	49,689.5	95.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,197.8	13,744.1	(1,546.3)	112.7
Даатгалын үйлчилгээ	87,009.3	84,189.5	2,819.8	96.8
Тээврийн хэрэгслийн татвар	7,341.8	6,501.5	840.3	88.6
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,765.0	1,559.5	205.5	88.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	96,318.0	96,175.9	142.1	99.8
Газрын төлбөр	6,458.3	5,694.1	764.2	88.2
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	282,080.8	280,712.6	1,368.2	99.5
Бараа үйлчилгээний бусад зардал	344,272.4	338,491.2	5,781.2	98.3
Бараа үйлчилгээний бусад зардал	59,120.0	55,379.6	3,740.4	93.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	285,152.4	283,111.6	2,040.8	99.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,364,819.1	923,173.2	441,645.9	67.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	69,436.9	69,436.0	0.9	100.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-	-	-
Засгийн газрын гадаад шилжүүлэг	69,436.9	69,436.0	0.9	100.0
Бусад урсгал шилжүүлэг	1,295,382.2	853,737.2	441,645.0	65.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	121,513.5	121,488.6	24.9	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	751,468.7	311,446.1	440,022.6	41.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	422,400.0	420,802.4	1,597.6	99.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,400,000.0	1,393,345.9	6,654.1	99.5
Тоног төхөөрөмж	1,400,000.0	1,393,345.9	6,654.1	99.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,854,949.8	27,995,036.8	859,913.0	97.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,601,462.6	26,421,972.0	1,179,490.6	95.7
Улсын төсвөөс санхүүжих	27,601,462.6	26,421,972.0	1,179,490.6	95.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,253,487.2	1,573,064.8	(319,577.6)	125.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,253,487.2	1,573,064.8	(319,577.6)	125.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,390.5	(2,390.5)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,663.0	(4,663.0)	-



3.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,082,884.1
УРСГАЛ ЗАРДАЛ	1,082,884.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,070.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,441.9
Үндсэн цалин	11,816.9
Гэрээт ажлын хөлс	625.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,195.2
Тэтгэврийн даатгал	5,195.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,080.0
Түлш, халаалт	4,080.0
Байрны түрээс	4,000.0
Хангамж, бараа материалын зардал	10,911.8
Бичиг хэрэг	636.8
Ном, хэвлэл	9,985.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	290.0
Эд хогшил, урсгал засварын зардал	404,496.8
Багаж, техник, хэрэгсэл	121,148.0
Тавилга	19,832.4
Урсгал засвар	263,516.4
Бараа үйлчилгээний бусад зардал	7,944.5
Бараа үйлчилгээний бусад зардал	5,144.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,800.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	633,813.9
Бусад урсгал шилжүүлэг	617,504.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	617,504.8
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,309.1
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	15,123.5
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,185.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,091,884.1
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,091,884.1
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000.0
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	983,009.6
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	107,874.5
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	9,000.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,000.0

